



## ОУИТБС-ын баруун бүсийн 2-р чуулганы тайлан

2015 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баруун бүсийн хоёрдугаар чуулганыг Баянхонгор аймгийн төвд 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдөр зохион байгууллаа. Чуулганд Говь-алтай, Баян-өлгий, Ховд, Баянхонгор аймаг, Цээл, Чандмань, Галуут, Жаргалант, Баян-овоо, Бөмбөгөр сумдыг төлөөлж орон нутгаас 78 төлөөлөл, Ай энд ди ХХК, Рео ХХК, Гоби коул энд энерги ХХК, Зоос гоулд ХХК зэрэг 4 компанийн 5 төлөөлөл, Улаанбаатар хотоос Татварын ерөнхий газар, иргэний нийгмийн Төлсөн авснаа нийтэл эвсэл, Монголын геологийн холбоо, ОУИТБС-ын ажлын албыг төлөөлсөн 10 төлөөлөл нийт 93 оролцогчид чуулав. Увс, Завхан аймагт урилга хүргүүлсэн боловч ирж оролцсонгүй. Бүртгэлийг хавсаргав.



Чуулганы зорилго эрдэс баялгийн салбарын талаарх орон нутгийн иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, ил тод, хариуцлагатай уул уурхайн талаар нэгдсэн ойлголтыг бий болгох, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн харилцан ойлголцол хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршиж, баруун бүсийн тусгай зөвшөөрөл олголт түүний ил тод байдал, татвар төлөлтийн идэвх буюу эдийн засгийн үр нөлөө, компаниудын нийгмийн хариуцлага буюу

хандив, дэмжлэг, хөрөнгө оруулалт, байгаль орчны нөхөн сэргээлт зэрэг дэд сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хэлэлцүүлгээс гарсан санал, илтгэлүүдийг хураангуйлбал:

- Баянхонгор аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Гантулгын мэдээлснээр тус аймагт шинээр тусгай зөвшөөрлийн 65 өргөдөл ирснээс орон нутаг дэмжсэн 15, заасан хугацаанд хариу ирүүлээгүй 8, орон нутаг дэмжээгүй 19 өргөдөлд албан тоотоор хариу хүргүүлсэн байна. Ашигт малтмалын газар нь дэмжээгүй 19 өргөдлийг татгалзах хууль зүйн үндэслэл байхгүй байна гэсэн шалтгаанаар 11 өргөдлийг нь олгохоор шийдвэрлэсэн байна. Ингээд нийт 30 тусгай зөвшөөрөл шинээр олгогдохоор шийдвэрлэгджээ. Аймгийн зүгээс алслагдсан сумдаас 30 хоногийн дотор албан тоотоор хариу авахад хугацаа хүрэлцэхгүй, хүндрэлтэй байгаа тул утсаар болон цахимаар холбогдож саналыг авч байгаа ба сум, орон нутаг хэрэв шинээр тусгай зөвшөөрөл олгохыг дэмжихгүй байгаа бол хууль зүйн үндэслэлээ сайтар гаргаж, хариу ирүүлэхийг сануулав. 2014 онд ашиглалтын 9, хайгуулын 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулсан. Нөхөн сэргээлт хийх журам баталж, 12 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан. Тэдгээр аж ахуйн нэгжүүдээс 2014 онд 2 тэрбум 17 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг аймагт хийсэн байна. Аж ахуйн нэгжүүдийн мөнгөн бус хандив, дэмжлэгийг хэрхэн бүртгэх, тайлагнах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөхийг хүсэв.

- Говь-алтай аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Э.Бямбаагийн мэдээлснээр тус аймгийн бүх суманд буюу 18 сумын 1 сая га талбайд шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших 250 өргөдөл ирсэн байна. Аймгийн ЗДТГ-аас төрийн сангийн сүлжээгээр дамжин бүх сумдтай холбогдож, сум бүрээс 200-аас доошгүй иргэдийн саналыг авсан байна. Иргэдийн 98,2% нь шинээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, нийт 250 өргөдлийн 42-т зөвшөөрсөн хариу хүргүүлжээ.
- Баян-өлгий аймгийн Засаг даргын орлогч Н.Санатбекийн мэдээлснээр тус аймагт шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших 66 өргөдөл ирснээс 35-ыг нь дэмжиж, 31 өргөдөлд урт нэртэй хуульд заасан үндэслэлээр мөн иргэдийн дэмжихгүй гэсэн саналыг дагуу татгалзсан хариу хүргүүлсэн. Одоогийн байдлаар шинээр 36 хайгуулын лиценз олгохоор шийдвэрлэгдсэн байна.
- Ховд аймгийн Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Х.Баасанхүүгийн мэдээлснээр тус аймагт шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших 120 өргөдөл ирж, 60 хувьтай дэмжээд явж байна. Зарим өргөдөл хүссэн талбайд яалт ч үгүй гол орчихсон байхад Ашигт малтмалын газраас олгох боломжтой гээд орон нутгаас санал авахаар ирүүлээд байна. Аймгийн зүгээс сум нь дэмжиж байгаа бол тэр голтой хэсгийг нь хасаад олгох боломжтой гэх зэрэг байдлаар аль болох дэмжээд явж байгаа. Тиймээс цаашид Ашигт малтмалын газрыг урт нэртэй хуульд заасан газруудад өргөдөл хүлээн авахгүй байх, сайтар нягтлаж байхыг хүсч байна.
- Монголын геологийн холбооны Э.Тодбилэг: Урт нэртэй хуулийн асуудал бол Байгаль орчны яамны асуудал, та гол устай газраа Байгаль орчны яаманд мэдээлэх ёстой. Байгаль орчны яам эдгээр газруудад тусгай зөвшөөрөл олгож болохгүй гээд Ашигт малтмалын газарт чиглэл өгч байгаа. Ашигт малтмалын газар бүх тусгай хэрэгцээний газруудаа хасаад нийт газар нутгийн үлдэх 19%-д нь хайгуул хийх боломжтой гээд өргөдөл авч эхэлсэн байгаа. Ер нь аливаа Засгийн газрын тогтоол гарахдаа холбогдох бүх яамдаас нь санал авч байж гардаг. Ер нь уул уурхайн салбараа хөгжүүлэе гэвэл хайгуул хийж бид юутайгаа мэдэж байж л хөгжинө.
- Баянхонгор аймгийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын дарга Нансалмаа: Түйн голын эх дээр Монголросцветмет ХХК-ийн хайгуулын тусгай зөвшөөрөл байдаг. Бүх шатанд тус газрыг голын эх, тусгай хамгаалалттай газар гээд ашиглалтын зөвшөөрөл болгох боломжгүй гэсэн дүгнэлт гарсан байхад 281 тоот тушаалаар Ашигт малтмалын газар тусгай зөвшөөрөл олгосон байдаг. Тэгэхээр Байгаль орчны яамны саналыг Ашигт малтмалын газар харгалзаж үздэггүй юм биш үү.
- Баянхонгор сумын иргэн: Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах нэг л үндэслэл байдаг. Тэр бол улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан бол гэж хуулинд байгаа. Газрын тухай хуулиараа малчдад 50 жилээр өвөлжөө, хаваржааны газар эзэмш гээд гэрчилгээ өгчихөөд энд чинь уул уурхайн үйлдвэрлэл явуулна аа гээд тусгай зөвшөөрөл өгөөд эцэст нь нутгийн удирдлага, малчид, компани хооронд зөрчил үүсдэг. Хуулийн энэ тодорхойгүй, уялдаагүй байдлаас болоод сум орон нутаг нь мэддэг юм шиг, эсхүл малчид нь мэддэг юм шиг, эсхүл сүүлийн үед иргэний нийгмийн байгууллагууд мэдээд байгаа юм шиг ийм ойлгомжгүй байдал газар аваад байна. Цаашлаад ярьвал их юм бий. Тиймээс хуулиудаа сайн уялдуулж байхыг хүсч байна.
- Ховд аймгийн Засаг даргын орлогч Д.Амарсанаа: Уул уурхайн салбар нь эдийн засгийн тэргүүлэх салбар л юм бол энэ салбарын ашиг тус, ач холбогдлыг сумын иргэдэд ойлгуулах ажлыг хийдэг орон тооны мэргэжилтэнг Хөгжлийн бодлогын хэлтэст ажиллуулах хэрэгтэй. Одоо байгаа бүтцээр бол байгаль орчин, уул уурхай, газар гээд олон асуудлууд нэг л хүнд хариуцуулсан байдаг. Гэтэл авдаг цалин нь хэд билээ. Мэдээлэл өгдөг ийм хүн байвал илүү үр дүнтэй байх. Цалинг нь нэмдэггүй юмаа гэхэд урамшуулал олгох тогтолцоог бий болгох, ядаж бензиний зардал тавьж өгөх хэрэгтэй. Эдгээрийг шийдэхгүйгээр уул уурхайг хөгжүүлнэ гэдэг хүндрэлтэй.

- Чандмань, Жаргалант сумын Засаг дарга нар хууль батлахдаа салбар хоорондын уялдааг сайтар хангаж байж батлах, нэгдсэн салбарын бодлоготой байхыг сануулав.
- Ховд аймгийн ХБХ-ийн мэргэжилтэн Х.Баасанхүү орон нутагтай байгуулсан гэрээний талаар мэдээлэл хийв. Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-ийн дагуу МоЭнКо ХХК-тай 2007 оноос хойш гэрээ байгуулан ажиллаж байна. Анх хамтран ажиллах гэрээг тус компани баг, сум, аймаг гээд бүх шатанд 4-5 гэрээ байгуулдаг байсан. 2 жилийн өмнө ОУИТБС-ын баруун бүсийн анхдугаар чуулга уулзалтын үеэр гэрээний ил тод байдлыг хэлэлцэж, аймаг эрх мэдлээ төвлөрүүлээд сумдын саналыг тусган нэг л гэрээ байгуулах нь үр дүнтэй гэдэг дээр санал нэгдсэн. Үүний дагуу 2014 оны 6 сард гэрээ шинэчлэн байгуулж урд нь байгуулсан бүх гэрээг хүчингүй болгосон. Өмнөх гэрээнүүдээс маш олон сургамж олж авсан байна. Тухайлбал гэрээ баталсан орон нутгийн удирдлага солигдсоноос гэрээг дүгнэх, хэрэгжүүлэх бололцоогүй байсныг залруулж энэ удаа 4 албан тушаалтан баталдаг болгосон байна. Түүнчлэн өмнөх гэрээ тодорхой, товч байснаас талуудад олон маргаан дагуулж, сум орон нутаг хохирч байсан тул шинэ гэрээг 21 зүйл, 118 заалттай маш нарийвчилсан, хоёрдмол утгагүйгээр байгуулсан байна. Гэрээнд ажиллах хүчний 70 хувийг орон нутгаас авна гэж оруулж өгснөөр олон хүн ажлын байртай болсон байна. Өмнө нь хотын жолооч нар ирж машин бариад буцдаг байсан бол одоо 700 гаруйг нь орон нутгаас авч ажиллуулснаар маш том өгөөжийг орон нутагт бий болгожээ. Бас нэг алдсан зүйл нь гэрээндээ ханган нийлүүлэлтийн талаар “машин техник түрээслэсэн тохиолдолд 50%-ийг нь орон нутгаас хангана” гэж оруулснаар тухайн компани түрээслэхгүйгээр өөрсдөө худалдаж авсан байна. Тиймээс гэрээний зүйл, заалтыг хоёрдмол утгагүйгээр, сул үггүй, нарийн тодорхой зааж өгөх нь аль аль талдаа ашиг тустайг онцлов.
- Бөмбөгөр сумын малчин Батсайхан: Нүүдлийн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайгүйгээр монгол орныг төсөөлөхийн аргагүй. Гэтэл энэ 3 салбар бие биедээ дарамт болохгүйгээр, нэг нь нөгөөгөө устгахгүй байхаар төр засаг зохицуулах хэрэгтэй. Ухна гээд байгаа уурхайн буруу биш, ухуулахгүй гээд байгаа бидний ч буруу биш. Энэ хууль дүрмийг малчдын амьдрал мэдэхгүй, амьдралаас хол тасархай хүмүүс баталж байгаагийн гороор бидний амьдралд маш их дарамт учруулж байна. Үүнийг та бүхэн анхааралдаа авч, зохицуулж өгөхийг хүсье.
- ГОУХАН О.Батболд: Сэлэнгэ аймаг бол газар тариалан, мал аж ахуй, уул уурхайтай аймаг. Тэд уул уурхайн талаар баримтлах бодлогоо аймгийн түвшинд хэлэлцэж баталсан анхны аймаг болсон. Зарим зүйл заалт нь олон маргааныг зохицуулахад тус нэмэр болж байгаа. Тэгэхээр та бүхэн ч бас ийм бодлогын баримтаа боловсруулах нь зүйтэй. Хоёрдугаарт, хайгуулын компани юу хийгээд байгаа нь мэдэгдэхгүй байгаа учраас иргэдийн хардалт үүсдэг. Тиймээс хайгуулын компаниуд ч ил тод байх ёстой.
- Геологийн холбоо Э.Тодбилэг: манай компаниуд хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд байгаад гол асуудал байна. Ил тод байдал хөгжих бас нэг тулгуур бол хувьцаат компанийн засаглал юм. Тиймээс аль болох нээлттэй компани руу явах, дагаад манай хөрөнгийн бирж хөгжих хэрэгтэй.
- Ш.Цолмон: Бид Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулаад явж байна. ОУИТБС-ыг хэрэгжүүлснээр асуудал байна, бэрхшээл байна гэдгийг ил тодоор гаргаж ирж байна. Харин ямар гарц байна гэдгийг 3 талын оролцоотойгоор нээлттэй хэлэлцэх хэрэгтэй. Энэ талбар нь ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөл байх гэдэг гаргалгааг бид санал болгоод байгаа юм. Та бүхэн аймгийн дэд зөвлөлөөрөө асуудлаа хэлэлцээд шууд Ерөнхий сайдад хандаж болно ш дээ. Ингэхдээ компанийг оролцуулах ёстой, иргэдийг оролцуулах ёстой. 3 талын зөвшилцлийн механизмийг бий болгох явдал нь ОУИТБС-ын бас нэгэн зорилго юм. Өнөөг болтол компаниуд хаагдмал, үл тоосон байдлаар хандаж ирсэн түүх бий. Үүнийг өөрчлөх хэрэгтэй.

- Б.Дэлгэрмаа: Мэдээлэлтэй, мэдлэгтэй иргэдийг л чадавхжуулах хэрэгтэй. Манай соёлын онцлогоос болоод иргэд тэр болгон хэлэлцүүлэг, аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй. Гэсэн хэдий ч мэдээллийг тогтмол өгснөөр иргэдийн хяналтыг бий болгоход бага боловч хувь нэмэртэй юм.

Хэлэлцүүлгийн төгсгөлд салбар зөвлөл байгуулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөв. Оролцогчдоос чуулганы үр дүнгийн талаар санал асуулга авахад 77% нь хангалттай, 17% нь дунд, 6% нь хангалтгүй гэсэн үнэлгээг өгчээ.

- Олборлолтын үйл ажиллагаа явуулж буй компаниудыг оролцуулж тайланг тавих
- Уун чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ОУИТБС-ыг тогтвортой сайн хэрэгжүүлэх
- Хууль эрх зүйд хэр нийцэж байгаа талаар мэдээлэл байхгүй байна
- Засгийн газрын бодлого иргэдийн саналтай уялдаж байх ёстой.
- Уул уурхайг хариуцлагатай байлгах
- Уул уурхайг сум орон нутагт ажиллуулахгүй байх нь зүйтэй, малчдыг бодох хэрэгтэй
- Компанийн төлж буй бүх татвар, төлбөр суманд биш улс, аймагт орох мөн эргэн байгаль орчинд зарцуулагддаггүй. 1 сумаас орсон уурхайн татварууд бусад сумын БХ ажлууд хийгддэг. Энэ асуудал суманд тэр дундаа багийн иргэдэд гомдол их байна.
- Тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн компаниудын ил тод байдал, нөхөн сэргээлтийн талаар мэдээлэл авч байх
- Уурхайтай суманд бололцоо байвал уул уурхайн төлөөлөгчийг байлгаж тухайн орон нутгийн иргэдийг өргөнөөр хамруулж уулзалт, мэдээлэл хийх хэрэгтэй.
- Иргэдэд тэнцвэртэй үнэн зөв мэдээллийг хүргэх
- Нутгийн иргэдийн эрх ашгийг тэдэнд сайн ойлгуулах
- Алтайн хүдэр ХХК-ийн төлөөлөл ард иргэдийн хоорондох уялдаа холбоог сайжруулах талаар уулзалт, сургалт зохион байгуулж өгнө үү.
- Уул уурхайн яам, орон нутгийн удирдлагууд уялдаа холбоотой зөв шийдвэр гаргаж хэн нэгэнд чирэгдэл учруулахгүйгээр зөв зохистой бодлого боловсруулж ажиллах
- Уул уурхайн талаар үнэтэй мэдлэг олгож өгсөнд баярлалаа
- Өнөөдрийн өдөрлөг шиг мэдээллийг сум болгонд хиймээр байна.
- Олборлолт дууссан газруудын нөхөн сэргээлтийг хийлгэж, түүнд хяналт тавих, уул уурхайн талаар иргэдэд мэдээлэл сурталчилгааг явуулах хэрэгтэй
- Ард иргэдэд мэдээллээ сайн хүргэх, иргэдийг идэвхжүүлэх
- Уул уурхайг орон нутагтаа ажиллуулмааргүй байна.
- Татварыг орон нутагт, багт төвлөрүүлдэг байх
- Цаашид ийм сургалт явуулж байх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэх
- Иргэдэд зөв, үнэн мэдээлэл маш сайн хүргэх
- Сайн мэдээлэл өгсөн та бүхэнд баярлалаа. Түйн голын ус бохирдож байна.
- өнөөдрийн уулзалт маш сайн болсонд баярлалаа
- Асуудал сайн шийдэх хэрэгтэй
- Түйн голын эхэнд байгаа Эрдэнэцогт суманд лиценз битгий олгоорой. Хонгорын хөдөлмөрчид бид амьдрах боломжтой болох аюултай.
- 3 талт хамтын ажиллагааг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй баймаар байна.

Чуулганы үйл ажиллагааг Баянхонгор аймгийн телевиз, сонины сэтгүүлчид сурвалжлан олон нийтэд мэдээлэв. Төгсгөлд нь Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар нийт оролцогчдод Баянхонгор аймагт хийсэн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажилтай танилцах аялалыг зохион байгуулав. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга төслөөс Баянхонгор аймгийн тайланг бэлтгэж, хэвлэн нийтлэх, Баянхонгор аймгийн Жаргалант, Бөмбөгөр, Баян-овоо, Галуут сумдаас оролцсон төлөөлөгчдийн томилолт болон унааны зардлыг санхүүжүүлж, бусад зардлыг ОУИТБС-ын ажлын алба санхүүжүүлсэн болно.

Хянасан:

Ш.Цолмон

Тайлан бичсэн:

Б.Дэлгэрмаа